

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:dolgorsurenb@audit.gov.mn">dolgorsurenb@audit.gov.mn</a> Ахлах аудитор П.Амарсанаа Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:Amarsanaap@audit.gov.mn">Amarsanaap@audit.gov.mn</a> Ахлах аудитор С.Отгонхорлоо Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:otgonkhorloos@audit.gov.mn">otgonkhorloos@audit.gov.mn</a> Аудитор С.Шийлэгмаа Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:shiilegmaas@audit.gov.mn">shiilegmaas@audit.gov.mn</a> Аудитор Н.Нямсүрэн Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:nyamsurenn@audit.gov.mn">nyamsurenn@audit.gov.mn</a> Аудитор Ж.Мөнхтуул Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:munkhtuulj@audit.gov.mn">munkhtuulj@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл .....
- 4.2 Материаллаг байдал .....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГ	Засгийн газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
НАӨТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат кампани
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай кампани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
П.БОЛДБААТАР ТАНАА

2026.03.16 № 638  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тайланд онд 54 аж ахуйн нэгж харилцагчтай 121.2 сая төгрөг, 3 иргэнтэй 20.7 сая төгрөгийн авлагын, 21 аж ахуйн нэгж харилцагчтай 3,460.3 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн 1,673.2 сая төгрөгийн тооцооллыг иж бүрэн, үнэн зөв, стандартын дагуу тооцоолол хийж бүртгээгүй;
- Татварын тайлантай холбоотой өглөг, авлагын үлдэгдлийг 503.0 сая төгрөгийн санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй;
- Авлигатай тэмцэх газар Хаард стийл ХХК-ийн 238.4 сая төгрөгийн Д/2025-284 дугаар гэрээ, 37.7 сая төгрөгийн Д/2025-136 дугаар гэрээ, Эрхэм ивээл ХХК-ийн 105.2 сая төгрөгийн Д/2025-238 дугаар гэрээ, нийт 381.3 сая төгрөгийн гэрээ болон тендерийн материалыг шалгахаар авч явсан тул аудитад хамруулах боломжгүй байсан;

- Хөгжлийн банкны зээлийн урт хугацаат зээлийн эргэн төлөлтийг 2024 оны 06 дугаар сараас хойш хуваарийн дагуу төлөөгүй, өмнөх оны үндсэн төлбөрийн үлдэгдэл 3,392.2 сая төгрөг, тайлант оны эцэст 33,568.9 сая төгрөгийн үндсэн төлбөр, 30,118.8 сая төгрөгийн хүүгийн төлбөр, 24.2 сая төгрөгийн нэмэгдэл хүү, нийт 67,104.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6-эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1 "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", 83.6 "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна", Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна", Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-д зээлдэгч эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрийг төлнө, 5.2-т зээлийн төлбөрийг төлөөгүй эсхүл дутуу төлсөн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү, үндсэн хүү, үндсэн зээл гэсэн дарааллаар төлнө, Монгол Улсын Иргэний тухай хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-д Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "үнэн ба зөв", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийг Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолоор бие даасан төрийн өмчит хувьцаат компани болгосон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 13 тогтоолоор Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж, 14 дүгээр тогтоолоор төрийн өмчийн 66.0 хувийг Эрчим хүчний яам, 34.0 хувийг Эрчис Монгол ТӨХК, эзэмшихээр дахин хувь хэмжээг өөрчилсөн байна. Эрчис Монгол ТӨХК-тай хийсэн менежментийн гэрээгээр 1,392.5 сая төгрөгөөр гэрээлсний дагуу 280.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант онд Зуух 1-4-ийн хяналт удирдлагын DCS системийн шинэчлэх ажилд Yokogawa electric korea компанид 5,565.6 сая төгрөг, мөн зуух 1-д 8,037.4 сая төгрөг, зуух 5-д 6,321.2 сая төгрөгийг их засварын ажилд зарцуулсан байна.

## **Бусад асуудал**

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 55 дугаар тогтоолоор 2025 оны 03 дугаар сард энергийн 1 кВт/ц-ын тарифыг 66.39 төгрөгөөс 55.43 төгрөг, чадлын тарифыг 41,145.3 сая төгрөгөөс 23,637.3 сая төгрөг болгон бууруулснаар Диспетчерийн үндэсний төвийн борлуулсан цахилгаан эрчим хүчний орлого 10,472.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэл



Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2025 оны 1 сарын 01	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,189,565,434.99	4,816,536,214.09
1.1.2	Дансны авлага	33,370,352,356.13	51,863,574,775.12
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,549,611,200.22	6,255,315.31
1.1.4	Бусад авлага	380,914,577.99	363,381,387.88
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	37,027,359,079.73	32,650,749,757.49
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	7,173,136,829.04	9,226,617,982.62
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/	-	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>83,690,939,478.10</b>	<b>98,927,115,432.51</b>
<b>1.2</b>	<b>Эргэлийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	817,222,074,036.93	784,810,102,410.24
1.2.2	Биет бус хөрөнгө	77,370,864,709.00	77,795,230,698.18
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,071,355,367.71	2,519,011,464.81
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>896,664,294,113.64</b>	<b>865,124,344,573.23</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>980,355,233,591.74</b>	<b>964,051,460,005.74</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,098,424,629.12	6,069,798,667.85
2.1.1.2	Цалингийн өглөг	9,208,830,113.58	11,444,713,701.73
2.1.1.3	Татварын өр	1,998,104,680.53	2,369,228,150.59
2.1.1.4	НДШ-ийн өглөг	24,988,587.40	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	52,577,886,635.22	89,536,370,206.51
2.1.1.6	Хүүний өглөг	11,293,112,477.00	30,569,970,328.48
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,037,097,801.78	8,671,301,925.26
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	7,339,214,943.04	5,902,126,082.88
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,867,326,144.66	1,871,628,491.32
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах бүлэг хөрөнгө/-нд хамаарах өр төлбөр	-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>87,444,986,012.33</b>	<b>156,435,137,554.62</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	332,925,785,905.13	284,326,300,414.25

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	15,323,810,723.00	10,425,694,798.73
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,673,209,875.52	1,673,209,875.52
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	16,086,990,204.77	15,161,436,699.89
2.1.2.5	Хойшлогдсон орлого	-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>366,009,796,708.42</b>	<b>311,586,641,788.39</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>453,454,782,720.75</b>	<b>468,021,779,343.01</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч	228,213,686,843.34	228,213,686,843.34
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	257,138,427,145.56	257,138,427,145.56
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	76,866,273,164.00	76,866,273,164.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-35,317,936,281.91	-66,188,706,490.17
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>526,900,450,870.99</b>	<b>496,029,680,662.73</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>980,355,233,591.74</b>	<b>964,051,460,005.74</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>	<b>453,737,597,567.53</b>	<b>543,037,232,678.91</b>
2	Борлуулалтын өртөг	482,607,511,218.74	562,243,343,167.38
<b>3</b>	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>-28,869,913,651.21</b>	<b>-19,206,110,488.47</b>
4	Түрээсийн орлого	223,754,503.08	251,008,824.47
5	Хүүний орлого	127,577,647.47	137,548,483.62
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	36,812,719,289.23	8,688,871,504.59
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,843,715,685.72	3,293,402,175.09
10	Ерөнхий удирдлагын зардал	8,046,711,566.94	8,825,264,728.23
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	14,271,606,298.77	4,344,074,540.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	17,182,392,648.55	-4,286,393,854.86
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	-	-
17	Бусад ашиг /алдагдал/	2,474,345.91	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>316,971,231.60</b>	<b>-30,877,816,974.85</b>
19	Орлогын татварын зардал	1,873,806,122.95	13,754,848.36
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>-1,556,834,891.35</b>	<b>-30,891,571,823.21</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-1,556,834,891.350</b>	<b>-30,891,571,823.21</b>

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз /гарз/	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/</b>		

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>228,213,686,843.34</b>	<b>257,138,427,145.56</b>	<b>76,866,273,164.00</b>	<b>35,317,936,281.91</b>	<b>526,900,450,870.99</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	<b>2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>228,213,686,843.34</b>	<b>257,138,427,145.56</b>	<b>76,866,273,164.00</b>	<b>35,317,936,281.91</b>	<b>526,900,450,870.99</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	20,801,614.95	<b>20,801,614.95</b>
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>228,213,686,843.34</b>	<b>257,138,427,145.56</b>	<b>76,866,273,164.00</b>	<b>35,297,134,666.96</b>	<b>526,921,252,485.94</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	30,891,571,823.21	<b>-30,891,571,823.21</b>

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	<b>2025 оны 06-р сарын 30-ны үлдэгдэл</b>	<b>228,213,686,843.34</b>	<b>257,138,427,145.56</b>	<b>76,866,273,164.00</b>	<b>66,188,706,490.17</b>	<b>496,029,680,662.73</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн +/-	<b>456,437,843,816.44</b>	<b>520,095,683,052.24</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	425,357,757,977.37	516,029,590,406.21
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	28,041,030,000.00	-
	Бусад мөнгөн орлого	3,039,055,839.07	4,066,092,646.03
1.2	Мөнгөн зарлагын дүн +/-	<b>463,468,888,077.66</b>	<b>506,160,171,074.50</b>
	Ажиллагчдад төлсөн	74,267,882,393.00	74,862,079,612.40
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	19,937,000,000.00	23,870,348,407.00
	Бараа материал худалдан авахад	185,354,366,747.34	68,736,102,723.17
	Ашиглалтын зардалд төлсөн	-	180,109,734.36
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	72,423,437,957.52	284,785,230,394.77
	Хүүгийн төлбөрт төлсөн	27,838,704,509.24	20,378,875,670.21
	Татварын байгууллагад төлсөн	34,052,529,195.97	17,243,033,628.72
	Даатгалын төлбөрт төлсөн	5,280,012.00	-
	Бусад мөнгөн зарлага	49,589,687,262.59	16,104,390,903.87
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-7,031,044,261.22</b>	<b>13,935,511,977.74</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн +/-	<b>127,577,647.47</b>	<b>137,548,483.62</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан**

	Хүлээн авсан хүүний орлого	127,577,647.47	137,548,483.62
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн /-/</b>	<b>4,857,086,254.51</b>	<b>4,288,346,311.86</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,857,086,254.51	4,288,346,311.86
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-4,729,508,607.04</b>	<b>-4,150,797,828.24</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн +/-</b>	<b>18,000,000,000.00</b>	<b>500,000,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,000,000,000.00	500,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн /-/</b>	<b>16,116,190,984.64</b>	<b>9,698,269,286.26</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	16,000,000,000.00	9,698,269,286.26
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	116,190,984.64	-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,883,809,015.36</b>	<b>-9,198,269,286.26</b>
3.4	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>0.00</b>	40,525,915.87
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-9,876,743,852.90</b>	<b>626,970,779.11</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	14,066,309,287.89	4,189,565,434.99
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	4,189,565,434.99	4,816,536,214.09

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Өөрчлөлт		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төл-с	Гүйц-с	
1	Боловсруулсан	ЦЭХ	сая кВт.ц	4,985.9	4,804.4	5,008.6	204.2	22.7
		ДЭХ	мян.Гкал	4,733.8	5,113.2	5,008.9	-104.3	275.1
	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	11.03	11.30	11.08	-0.22	0.06
		биетээр	сая кВт.ц	549.7	542.9	555.1	12.2	5.4
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая кВт.ц	4,436.1	4,261.6	4,453.5	191.9	17.4
		ДЭХ	мян.Гкал	4,733.8	5,113.2	5,008.9	-104.3	275.1
2	<b>Нийт орлого</b>		<b>сая төг.</b>	<b>508,086.5</b>	<b>537,213.2</b>	<b>552,114.7</b>	14,901.4	44,028.1
	Үүнээс: Борлуулалтын орлого		сая төг.	453,737.6	530,967.2	543,037.2	12,070.1	89,299.6
	Үүнээс:	ЦЭХ	сая төг.	419,182.0	510,401.1	521,582.3	11,181.2	102,400.3
		ДЭХ	сая төг.	34,555.6	20,566.1	21,454.9	888.9	-13,100.7
	Улсын төсвийн санхүүжилт /Татаас/		сая төг.	25,491.8	0.0	0.0	0.0	-25,491.8
	Үйл ажиллагааны бус орлого		сая төг.	28,857.1	6,246.1	9,077.4	2,831.3	-19,779.6
3	<b>Нийт зардал</b>		<b>сая төг.</b>	<b>507,769.5</b>	<b>566,070.3</b>	<b>578,706.1</b>	12,635.8	70,936.5
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		сая төг.	503,910.3	560,841.7	574,450.0	13,608.3	70,539.8
	Үүнээс:	Түлш	сая төг.	238,189.4	283,624.7	286,555.7	2,931.0	48,366.3
		Элэгдэл	сая төг.	71,439.5	73,811.9	86,214.5	12,402.6	14,775.0
		Бусад тогтмол	сая төг.	194,281.4	203,405.2	201,679.9	-1,725.2	7,398.5
	Үйл ажиллагааны бус зардал		сая төг.	3,859.3	5,228.6	4,256.0	-972.6	396.8
Валютын ханшийн бодит бус ашиг/алдагдал		сая төг.	17,182.4	0.0	-4,286.4	-4,286.4	-21,468.8	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг.	317.0	-28,857.1	-30,877.8	-2,020.8	-31,194.8
ААНОАТ		сая төг.	1,873.8	1,017.5	13.8	-1,003.7	-1,860.1	
5	<b>Татварын дараах ашиг /алдагдал/</b>		сая төг.	<b>-1,556.8</b>	<b>-29,874.5</b>	<b>-30,891.6</b>	-1,017.0	-29,334.7
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.11	1.07	1.06	-0.01	-0.1
7	<b>Нийт авлага</b>		<b>сая төг.</b>	<b>35,300.9</b>	<b>20,020.0</b>	<b>52,233.2</b>	32,213.2	16,932.3
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг.	33,370.4	20,020.0	51,863.6	31,843.6	18,493.2
		бусад	сая төг.	1,930.5	0.0	369.6	369.6	-1,560.9
8	<b>Нийт өглөг</b>		<b>сая төг.</b>	<b>453,454.8</b>	<b>570,747.2</b>	<b>468,021.8</b>	-	14,567.0
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг.	87,445.0	166,147.2	156,435.1	-9,712.1	68,990.2
		Урт хугацаат өр төлбөр	сая төг.	366,009.8	404,600.0	311,586.6	-93,013.4	-54,423.2
9	Нийт ажиллагсад		тоо	1,486	1,490	1,486	-4.0	0.0
10	<b>Нийт цалингийн сан</b>		<b>сая төг.</b>	<b>81,060.9</b>	<b>88,097.8</b>	<b>92,125.0</b>	4,027.2	11,064.1
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВт.ц	273.42	274.44	274.18	-0.26	0.75
		дулаан	кг/Гкал	171.52	171.53	171.20	-0.32	-0.31
12	<b>Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт</b>		<b>сая төг.</b>	<b>43,732.6</b>	<b>62,808.5</b>	<b>55,311.7</b>	-7,496.8	11,579.1

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн эрхэм зорилгыг “Эх орны хөгжлийн баталгаа, эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна” гэж тодорхойлжээ.

Тус компани нь дээрх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлж ажилласан байна. Үүнд:

- Компанийн үндсэн зорилт нь тодорхой үйлчилгээ явуулах нутаг дэвсгэртээ хэрэглэгчийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай бүрэн хангах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллахад оршино.
- Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, үйлдвэрлэл эрхэлж, ажил, үйлчилгээ үзүүлнэ.
- Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- Монгол Улсын хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрийн үндсэн дээр компани нь охин компанитай байж болно. Охин компанитай харилцах эрх зүйн байдлыг холбогдох хууль болон гэрээний үндсэн дээр зохицуулна.
- Компанийг Монгол Улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд заасны дагуу өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.
- Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна.

Цахилгааны, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, хангах, түгээх, худалдах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит хувьцаат компани юм.

#### 3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор, гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн тогтоолоор тус тус томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох”, 76 дугаар зүйлийн 76.1.8-д “Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэж заасантай нийцэж байна.

Компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд дараах хууль тогтоомж болон бодлого чиглэлийг мөрддөг бөгөөд тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2025 оны 55 дугаар тогтоолд өөрчлөлт орсон байна.

Компанийн мөрдөж байгаа хууль тогтоомжууд байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль,
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль.

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналтын хэлтэс 24 ажилтантай бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал, техникийн албаны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, ТУЗ-ийн дэргэд орон тоо баталсан боловч ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар тогтоолоор шууд удирдлагад харьяалагдах дотоод аудиторын албан тушаалыг бий болгон одоогоор ажилтан ажиллаагүй, компанийн удирдлагыг ирээдүйд учирч болох санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллээр хангаж чадаж байгаа эсэх нь тодорхой бус байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох хууль тогтоомж, компанийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан байна. Тус баримт бичгийг Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/336 дугаар тушаалаар шинэчилж, өөрчлөлт оруулсан боловч дахин нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/336 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,303.8 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,189,565.4	4,816,536.2	626,970.8
Авлага	35,300,878.2	52,233,211.5	16,932,333.3
Бараа материал	37,027,359.0	32,650,749.7	(4,376,609.3)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	7,173,136.8	9,226,618.0	2,053,481.2
Үндсэн хөрөнгө	896,664,294.1	865,124,344.6	(31,539,949.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>980,355,233.5</b>	<b>964,051,460.0</b>	<b>(16,303,773.5)</b>
Өр төлбөр	453,454,782.7	468,021,779.3	14,566,996.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	526,900,450.8	496,029,680.7	(30,870,770.1)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>980,355,233.5</b>	<b>964,051,460.0</b>	<b>(16,303,773.5)</b>

Хүснэгтээс харахад тайлант онд дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,816.5 сая төгрөг болж, 627.0 сая төгрөгөөр өссөн;
- Авлагын дансны үлдэгдэл 52,233.2 сая төгрөг болж, тайлант онд Диспетчерийн үндэсний төв ТӨХК-аас авах цахилгаан эрчим хүчний борлуулалтын авлага 17,773.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, найдваргүй авлагын нөөц 493.3 сая төгрөг, 2024 онд урьдчилж төлсөн НӨАТ-ын 1,427.0 сая төгрөгөөр илүү төлөлт үүссэн, Сангийн яамны хоорондын тооцооны хаалтаар суутгасан татварын авлага барагдуулсан зэргээс шалтгаалан 16,932.3 сая төгрөгөөр өссөн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 32,650.7 сая төгрөг болж, тайлант онд өөрийн хөрөнгөөр 319,839.1 сая төгрөгийн бараа материал, 520.0 сая төгрөгийн бусад материал худалдан авсан, үйл ажиллагаанд 324,688.5 сая төгрөгийн бараа материал зарцуулсан, 207.3 сая төгрөгийн бараа борлуулсан, 123.6 сая төгрөгийн бараа материал акталж устгасан, 305.4 сая төгрөгийн бараа материалыг бусад шилжүүлсэн зэрэг нь нөлөөлж, 4,376.6 сая төгрөгөөр буурсан;
- Урьдчилж төлсөн зардал 9,226.6 сая төгрөг болж, тайлант онд нүүрс болон нүүрс, тээврийн зардалд урьдчилж төлсөн төлбөр 3,639.8 сая төгрөгөөр нэмэгдэж, бараа материалд төлсөн урьдчилгаа төлбөр 1,584.0 сая төгрөгөөр буурснаас шалтгаалан 2,055.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 31,539.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 3,670.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 49,812.8 сая төгрөгийн их засварын ажлыг биет хөрөнгөд капиталжуулан бүртгэж, нийт 53,483.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 85,895.8 сая төгрөгийн элэгдэл, хорогдол байгуулсан нь нөлөөлжээ. Тухайлбал: Барилга, байгууламж 5,175.7 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 42,331.5 сая төгрөг, бусад хөрөнгө 5,976.6 сая төгрөг, хувь тэнцүүлсэн НӨАТ 547.7 сая төгрөгөөр өсөж, барилгын хуримтлагдсан элэгдэл 8,045.5 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдэл 72,969.5 сая төгрөгөөр, бусад хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 4,880.8 сая төгрөгөөр байгуулсан, он дамжин хийгдэх засварын ажил 102.3 сая төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл 14,566.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд дансны өглөг 3,971.4 сая төгрөг, цалингийн өглөг 2,435.8 сая төгрөг, татварын өр 144.0 сая төгрөг, зээлийн хүүгийн өглөг 19,276.8 сая төгрөг, урьдчилж орсон орлого 7,634.2 сая төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 39,189.9 сая төгрөгөөр өсөж, урт хугацаат зээл 48,599.5 сая төгрөг, нөөц өр төлбөр 1,437.0 сая төгрөгөөр буурсан, богино хугацаат өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна;
- Тайлант оны эхэнд дамжуулан зээлдүүлсэн 5 зээлийн 48,233.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд хагас, бүтэн жилээр эргэн төлөлтийг төлөхөөр гэрээнд тусгасны дагуу зээлийн үндсэн төлбөрт 3,6740.5 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 889.5 сая төгрөгийг графикайн дагуу олгосон байна;
- Тайлант онд 30,891.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгаар 20.8 сая төгрөгийн алдагдлыг тус тус бүртгэснээс шалтгаалан хуримтлагдсан алдагдал 30,870.8 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 17 дугаар тогтоол, ЭХС-ын А/32 дугаар тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 595,191.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 574,903.1 сая төгрөгөөр, 16,116.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 66,684.0 сая төгрөгийг төлөвлөжээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 15 дугаар тогтоол, ЭХС-ын А/182 дугаар тушаалаар 2025 оны оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тодотгон нийт орлогыг 537,213.2 сая төгрөг, нийт зардлыг 562,344.5 сая төгрөг, алдагдлыг 25,131.2 сая төгрөг, их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын арга хэмжээг 62,808.5 сая төгрөгөөр баталсан байна. Тухайлбал, Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор үнэ тариф бууруулснаар нийт орлогыг 57,978.4 сая төгрөг, нийт зардлыг 12,558.6 сая төгрөг, их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын арга хэмжээг 3,875.5 сая төгрөгөөр бууруулж, алдагдлыг 9,014.8 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 18 дугаар тогтоол, ЭХС-ын А/251 дүгээр тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дахин тодотгон нийт орлогыг 537,213.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 566,070.3 сая төгрөгөөр, 29,874.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна. Тухайлбал, нийт зардлыг 3,725.8 сая төгрөг, алдагдалыг 4,743.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тодотгосон байна.

**Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Гүйцэтгэлээр 552,114.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, үйл ажиллагаанд 578,706.1 сая төгрөгийг зарцуулж, 30,877.8 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай тайлагнасан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 537,213.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 552,114.7 сая төгрөг буюу 14,901.4 сая төгрөгөөр 0.2 хувиар давсан нь Үндсэн үйл ажиллагааны орлого 12,070.1 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2,831.3 сая төгрөгөөр давсан нь нөлөөлжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 578,706.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 12,635.8 сая төгрөг буюу 0.2 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь түлшний зардал 2,931.0 сая төгрөг, элэгдлийн зардал 12,402.6 сая төгрөг, цалингийн зардал 4,027.2 сая төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 370 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 55,317.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хөрөнгө оруулалтын 34 төсөл арга хэмжээнд 7,758.7 сая төгрөг, ажил үйлчилгээний 71 төсөл арга хэмжээнд 41,114.4 сая төгрөг, 230 нэр төрлийн бараа худалдан авах 42,326.8 сая төгрөг, бусад ажил үйлчилгээний 35 нэр төрлийн арга хэмжээнд 1,799.4 сая төгрөг, нийт 92,999.4 сая төгрөгийг баталсан байна.

Тайлант онд ТУЗ-ийн 2025 оны 16 дугаар тогтоолоор 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан 4,772.4 сая төгрөгөөр бууруулж, 88,227.0 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны худалдан авах ажиллагааны тайланд 88,227.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 301 төсөл, арга хэмжээнд 78,476.2 сая төгрөгийн үндсэн гэрээ байгуулж, 2 төсөл арга хэмжээнд 52.4 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, 8 төсөл арга хэмжээнд 52.5 сая төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.

Тайлант оны тендер, худалдан авах ажиллагаанаас 6,721.6 сая төгрөгийн гэрээний хэмнэлт, 12.4 сая төгрөгийн шууд худалдан авалт, 1,666.7 сая төгрөгийн тендер зарлагдаагүй, 1,297.5 сая төгрөгийн тендер амжилтгүй болсноор нийт 9,698.3 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Тайлант онд 29,874.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр татварын өмнөх алдагдал 30,877.8 сая төгрөг, татварын дараах алдагдал 30,891.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,017.0 сая төгрөгөөр давсан нь Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2025 оны 55 дугаар тогтоолоор 58,744.9 сая төгрөгөөр бууруулж баталсантай холбоотой байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Хувьцаа эзэмшигчийн хурлын 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2024 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилаагүй, түрээсийн орлогын 40 хувь буюу 101.6 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлжээ.

**СУДАЛГААНЫ ҮР ДҮН:**

Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд судалгаа авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Дулааны IV цахилгаан станц ТӨХК, ҮЭХ-той 2024-2025 оны хамтын гэрээг 2024 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 16 дугаар тушаалаар батлагдсан, 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн гүйцэтгэх захирлын А/342 дугаар тушаалаар ажилтны нэг өдрийн хоолны мөнгийг 11.6 мянган төгрөгөөр тогтоосон.
2. Гадаад томилолтын зардалд 25.0 сая төгрөгийг төлөвлөснийг тодотголоор бууруулж, 10.0 сая төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэх захирлын Б/157 дугаар тушаалаар Бүгд найрамдах Чех улсын Прага хотод зохион байгуулагдах Монгол, Чех, Польшийн бизнес форумд оролцоход 9.2 сая төгрөгийг зарцуулсан.
3. Төрд учирсан хохирлоор авлага үүсээгүй, холбогдолтой асуудал байхгүй байна.
4. Тус компани 3,653.4 сая төгрөгийн гэрээний үнэтэй 34 нэр төрлийн лиценз, программ хангамжийг ашигладаг байна. Тайлант онд 917.7 сая төгрөгийн засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтаар 616.7 сая төгрөгийн хөгжүүлэлт хийсэн байна.
5. Сургалт хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний дагуу 254.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр тусгай эрхийн сургалт болон АЗ, Эрчим хүчний үндэсний төвийн сургалтад нийт 148.0 сая төгрөгийг зарцуулж, Засгийн газрын “Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 132 дугаар тогтоолоор үнэ тарифт өөрчлөл оруулахгүй гэснийг хэрэгжүүлж, 106.7 сая төгрөгийг хэмнэсэн байна.
6. Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар тогтоолоор 2025 оны 03 дугаар сараас мөрдөх үнэ тарифыг батлахдаа батлагдсан зорилтот түвшинд төлөвлөсөн үйл ажиллагааны борлуулалтын орлогыг 58,744.9 сая төгрөгөөр бууруулж, 530,967.2 сая төгрөг болгосноос шалтгаалан тайлант онд тодотгол хийх зайлшгүй шаардлага үүссэн байна.
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн “Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах” 2025 оны 03 дугаар тогтоолоор 1490 орон тоотой ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр Хяналтын хэлтсийн металл судлалын хяналтын инженер, Худалдан авах ажиллагааны хэлтсийн худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Борлуулалтын хэлтсийн борлуулалтын мэргэжилтэн, Санхүү бүртгэлийн хэлтсийн материал, сэлбэг хариуцсан нярав зэрэг нийт 4 орон тоог бууруулж, ажлын байрны чиг үүргийн хуваарилалт хийж, судалгааг үндэслэн гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/330 дугаар тушаалаар 1486 орон тоотой ажиллаж байна.
8. Хэвлэл мэдээллээр бараа материалын үлдэгдэлтэй холбоотой 30,000.0 сая төгрөг, хадгалах горим алдагдсан 1,800.0 сая төгрөг, тооллогоор илэрсэн 300.0 сая төгрөг, зуухны их засварын зардлыг 1,100.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн зэрэг 4 асуудлаар аудитын явцад судалж, горим, сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагааг сайжруулах урамшуулал, ХХОАТ, зардал, бараа материал зээл, татварын тайлан, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, их засвар, ТЗБАХ-тай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа, С.Отгонхорлоо, аудитор С.Шийлэгмаа, Н.Нямсүрэн, Ж.Мөнхтуул нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/147а дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тогтоох эх сурвалжийг орлогын дэлгэрэнгүй тайлан, суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 508,086.5 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 5,096.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сэлбэг хэрэгслийн зардлыг 94.2 сая төгрөг, материал, хангамжийн зардлыг 61.7 сая төгрөг, албан томилолтын зардал 49.0 сая төгрөг, конторын хангамжийн зардлыг 31.7 сая төгрөг, хэвлэлийн зардлыг 25.6 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд:**

**Илрүүлэлт 1.** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвд хамрагдах ажиллагсдын урьдчилан сэргийлэх үзлэг болон Firewall M470 total security лиценз худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч нэг эх үүсвэртэй гэж шууд гэрээ байгуулсан, "Компанийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах" ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч харьцуулалтын аргаар тендер зарласан, нийт 252.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажлын тендер шалгаруулах аргыг төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.9-т "Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална", 2.13-т "Төлөвлөгөөнд тусгагдсан тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, зохион байгуулах хугацаа, тендер шалгаруулалтын арга, бараа, ажил, үйлчилгээний төрөл, тухайн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, бүр захиалагч холбогдох өөрчлөлттэй холбоотой үндэслэлийг албан бичгээр үйлдэж, цахим системд хавсаргасан байх ба холбогдох этгээд түүнийг хянаж төлөвлөгөөний өөрчлөлтийг зөвшөөрнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, батлуулахгүйгээр худалдан авах ажиллагааны аргачлалыг өөрчилж зохион байгуулсан зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Илрүүлэлт 2.** Шаардлага хангахгүй ижил төстэй ажлын туршлага байхгүй, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэрийн өртэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй компаниудыг шалгаруулснаас шалтгаалан нэр бүхий 5 аж ахуй нэгж, байгууллагын 1,546.9 сая төгрөгийн гэрээний бараа материал шаардлага хангахгүй буцах, засварын ажил удаашрах, төлбөр тооцоо он дамжин хийгдэх, гэрээ цуцлах зэрэг эрсдэлүүд үүссэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2-т "сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан", 26 дугаар зүйлийн 26.4.1-д "энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх", 48 дугаар зүйлийн 48.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 48.2.2-т "үнэлгээний хороо байгуулах", 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шаардлага хангахгүй ижил төстэй ажлын туршлага байхгүй, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэрийн өртэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй байгууллагыг сонгон шалгаруулсан, бараа материал шаардлага хангахгүй буцах, засварын ажил удаашрах, төлбөр тооцоо он дамжин хийгдэх, гэрээ цуцлах

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

зэрэг эрсдэл үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**Нийцлийн асуудлаар өгсөн зөвлөмжүүд:**

Илрүүлэлт 1. Тус компани 2024 оны жилийн эцэст 1,556.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байхад Гүйцэтгэх захирлын "Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл олгох тухай" 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар компанийн нийт ажилчдад 7,998.6 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн 3.6-д "Байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 хүртэлх сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Тухайн ажилтан албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компани ашигтай ажиллаагүй байхад жилийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 2. Тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт болон, гэрээний тусгай нөхцөлд урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан боловч байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлд урьдчилгаа төлбөр олгоно гэж заасан нь тендерийн баримт бичиг дэх мэдээллүүд хоорондоо зөрүүтэй, тодорхойгүй байдлыг үүсгэсэн байна.

Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т "Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендер шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэхдээ ерөнхий, тусгай нөхцөл болон өгөгдлийн хүснэгт дэх мэдээллийг нягталж, зөрүүгүй мэдээлэл оруулж байх.

Илрүүлэлт 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй гэрээ хийж, ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг 2025 оны 9 дүгээр сарын 08-наас 24-ний өдрийн хооронд хийсэн боловч үзлэг, шинжилгээний нэгдсэн дүнгийн талаарх тайланг авч, гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гэрээт ажлыг дуусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хувь хүн, хуулийн этгээдтэй ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтийг бүрэн гүйцэтгүүлж, хэрэгжилтийн тайланг авч, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт 4. Тендерийн бичиг баримтын боловсруулалттай холбоотой дараах нийтлэг зөрчил илэрлээ. Үүнд:

- Өрлөг дулаалгын ажлын нээлттэй тендер шалгаруулалтад хараат бус гишүүн үнэлгээ өгөөгүй;
- ҮДЦС4/20250101057 дугаар тендерийн Үнэлгээний хорооны зөвлөмжид гүйцэтгэх захирлын шийдвэрийг тусгаагүй;
- Үнэлгээний хорооны зөвлөмжид огноо бичигдээгүй байна. Тухайлбал, ДЦС4/20250101035, ДЦС4/20250101039, ДЦС4/20250101040, ДЦС4/20250101041, ДЦС4/20250101042, ДЦС4/20250101051, ДЦС4/20250101052, ДЦС4/20250101054, ҮДЦС4/20250101057;

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- ҮБ №2 ийн дээврийн засвар, өргөтгөлийн шүүлтүүр заалны таазны цонх солих ажлын гэрээг гүйцэтгэгч тал баталгаажуулаагүй, огноо бичигдээгүй, аудитын явцад хавсаргасан;
- НТШ үнэлгээний хороо нь оролцогч байгууллагуудыг ерөнхий шаардлагад нийцсэн эсэхийг үнэлсний дараа шаардлага хангасан оролцогчдыг залруулга болон үнийн хөнгөлөлтийн хүснэгтээр байр эзлүүлж шалгаруулдаг процесстой боловч шаардлага хангаагүй компаниудыг залруулга болон үнийн хөнгөлөлтийн хүснэгтэд оруулснаар тууштай байдал алдагдсан;
- Зуухны лифт №1, 2-н их засвар /Е2008-019А/ ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлыг наряд хаасан тэмдэглэлтэй тулгаж үзэхэд 2025/7/31-нд дууссан боловч гэрээ дүгнэсэн актыг 2 сарын дараа буюу 2025/10/01-нд үйлдсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.3-т “үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих”, 48.5-д “Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална”, 52 дугаар зүйлийн 52.2-т “Энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан энэ хуульд зааснаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад цаг тухайд нь оролцох үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үнэлгээний хороо худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам, тендерийн баримт бичигт заасны дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх.

**Илрүүлэлт 5.** Тайлант онд байгуулсан гадаад гэрээнд олон улсын арбитраар шийдвэрлэх заалтыг тусгасан нь тухайн нөхцөл байдал тохиолдсон үед өндөр зардал гарах эрсдэлтэй байна. Тухайлбал, Уралын турбины завод ХК-тай байгуулсан №79-16/540-2025 дугаар "Нийлүүлэлтийн гэрээ" гэрээний 5.7-д "ОХУ-ын ХҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитраар шүүхэд хандаж шийдвэрлэнэ", Yokogawa Electric Korea Co., Ltd-тай байгуулсан Г/2025-02 дугаар "Зуух №1-4-ийн хяналт удирдлагын DCS системийн шинэчлэлт" гэрээний 11.7-д "аливаа маргааныг Солонгосын арилжааны арбитраар зөвлөлийн олон улсын арбитраар журмын дагуу арбитраар эцэслэн шийдвэрлэнэ" гэж заасан байна.

Энэ нь Компанийн тухай хууль 84 дүгээр зүйлийн 84.4.1-т “хууль болон компанийн дүрэм, журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх”, 84.4.2-т “үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримталж, энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ чанд биелүүлэх”, 84.4.3-т “компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гадаад гэрээг байгуулахдаа тухайн нөхцөл байдал тохиолдсон үед өндөр зардал гарах эрсдэл үүсэж болзошгүй нөхцөл байдлыг үнэлж, олон улсын арбитраар шийдвэрлэх заалтыг тусгах эсэхийг нягталж, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх боломжтой заалтыг тусгах зохицуулалт хийх.

**Илрүүлэлт 6.** Бохемиа Мюллер компанийн сервис үйлчилгээний гэрээнд огноо тавиагүй байгаа нь гэрээний 2.1-д “талууд гарын үсэг зурж, тамга дарснаас хойш 120 хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байна” гэж заасны дагуу хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болгон тухайн үйлчилгээ хэзээ дуусах, хүлээлгэж өгөх нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, гэрээний 3.2-т "Бүх тоног төхөөрөмж, материалыг ... DAP нөхцөлийн үндсэн дээр нийлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээний хэрэгжилтийг үнэлэх боломжийг бүрдүүлж, тухайн үйлчилгээ хэзээ дуусах, хүлээлгэж өгөх хугацааг тодорхой болгож, гэрээ байгуулсан огноог бүрэн бичиж, баталгаажуулж байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, холбогдох данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлж, алдаа, зөрчил илрүүлж, асуудлын бүртгэлээр танилцуулж, саналыг авсан. Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн аудитаар дахин нягталж тусгалаа.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 1/1575 дугаар албан бичгээр, хэрэгжилтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 1/1637 дугаар албан бичгээр ирүүлснийг аудитын явцад хянаж, үнэлэхэд зөрчлийг нөхөн төлүүлэхээр тогтоосон 12.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгуулахаар өгсөн 21,070.0 сая төгрөгийн 12 албан шаардлагыг бүрэн биелүүлж, 64.2 сая төгрөгийн 21 зөвлөмж өгснөөс, 2 зөвлөмжийг биелүүлээгүй, нийт хэрэгжилт 98.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	12,200.0	1	12,200.0	100.00
Албан шаардлага	12	21,070,675.9	12	21,070,675.9	100.00
Зөвлөмж	23	64,199.0	21	64,199.0	94.00
<b>Нийт дүн</b>	<b>36</b>	<b>21,147,074.9</b>	<b>34</b>	<b>21,147,074.9</b>	<b>98.00</b>

Хэрэгжээгүй хойшлогдсон татварын хөрөнгө, ор төлбөрийн тооцоол үнэн зөв хийгээгүй, анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй, зөвлөмжийн хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2024-2025 оны хамтын гэрээнд хуулиас давсан дараах заалтыг тусгасан нь компанийн тайлант оны зардлыг нэмэгдүүлж, ашигт ажиллагаанд нөлөөлж байгаа тул дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- 9.6-д “салбарын болон бусад салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан шагналын дагалдах мөнгийг сар бүр урамшууллыг тооцоолж хагас бүтэн жилээр 2 удаа олгох”;
- 14.4-т “Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтныг хамтын гэрээнд хамруулан сар жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлс цол, ажилласан жил, мэргэжлийн зэргийн нэмэгдлийг захиргаа олгоно”;
- 12.11-т “Эрчим хүчний салбарт, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цомхотгох, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангахаар ажилласан жилд ногдуулан 2-6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох”.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84,127.8 сая төгрөгийн 22 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 83,085.3 сая төгрөгийн 14 албан шаардлага хүргүүлж, 1,042.5 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 73,263.8 сая төгрөгийн залруулагдаагүй, материаллаг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитаар нийцлийн асуудлаар 9,837.6 сая төгрөгийн 8 зөрчил илэрсэнд, 1,799.4 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 8,038.1 сая төгрөгийн 6 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт 1.** Тайлант онд нийт 52,233.2 сая төгрөгийн авлага үүссэнээс шүүхийн шийдвэртэй 246.8 сая төгрөг, 2024-2025 оны 1 сард гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр 2024-2025 оны 1 дүгээр сард гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газарт 226.0 сая төгрөгийн авлагыг шилжүүлсэн боловч тайлант хугацаанд барагдаагүй, Ариунбуян хур ХХК, Убаши системс ХХК-ийн 17.5 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг эрэн сурвалжлах шийдвэр гарсан боловч тус авлага барагдаагүй;

Мөн урьдчилж орсон орлогын 15 аж ахуй нэгжтэй 14.5 сая төгрөгийн авлага, баталгаат хугацааны барьцааны г 268.2 сая төгрөгийн өглөг, гадаадын аж ахуй нэгжтэй байгуулсан 4 гэрээт ажлын 2,472.9 сая төгрөгийн өглөг, дотоодын 5 аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үлдэгдлийн 65.4 сая төгрөгийн өглөг үлдэгдлийг тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шүүхийн шийдвэр гарсан авлагыг барагдуулахад анхаарч ажиллаагүй, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 2.** Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 7 жилийн хугацаатай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар гэрээгээр 70.6 сая евро буюу 260,093.8 сая төгрөгийн урт хугацаат зээл авсан байна. Өмнөх оны зээлийн эргэн төлөлтөөс төлөгдөөгүй үлдсэн 3,392.2 сая төгрөгийн үндсэн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн 2025 оны хуваарийн дагуу төлөөгүйгээс 33,568.9 сая төгрөгийн үндсэн төлбөр, 30,118.8 сая төгрөгийн хүүгийн төлбөр, 24.2 сая төгрөгийн нэмэгдсэн хүүгийн төлбөр, нийт 67,104.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Монгол Улсын Хөгжлийн банкттай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-д зээлдэгч эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрийг төлнө, 5.2-т зээлийн төлбөрийг төлөөгүй эсхүл дутуу төлсөн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү, үндсэн хүү, үндсэн зээл гэсэн дарааллаар төлнө, Монгол Улсын Иргэний тухай хуулийн 453 дугаар

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

зүйлийн 453.1-д Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй гэж тус тус заасныг зөрчсөн байна..

**Шийдвэрлэсэн нь:** Төслийн зээлийн эргэн төлөлтийг графикт хугацаанд төлдөггүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 3.** Тайлант оны эхэнд 1347 тонн мазутын үлдэгдэлтэй байхад Интер стандарт нефть ХХК-тай 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр 2,315,700.0 мянган төгрөгийн 930 тонн мазут худалдан авах Д/2025-290 дугаар гэрээг байгуулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан "Аюулгүй нөөц бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт, өөрчлөх, нөхөн хангалт хийх журам"-ийн 6.1.1 а-д "Мазут нь горимын зохицуулалтаар хамгийн их зарцуулах 10 хоногийн нөөцтэй байх", АШБ-/СҮАЖ-СБХ08/01 маягтад мазутын нөөцийг улиралд 300 тн байхаар тогтоосноос 1,111.15 тонн буюу 2,485.1 сая төгрөгөөр илүү нөөц үүсгэсэн, оны эцэст 1,411.15 тонн буюу 3,156.0 сая төгрөгийн мазутын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тайлант оны эцэст байх шаардлагатай нөөцөөс илүү 2,485.1 сая төгрөгийн 1,111.15 тонн мазут худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 4.** Нүүрс худалдан авах гэрээг Багануур ХК, Шивээ-овоо ХК-тай байгуулж, гэрээнд зааснаас илүү гарган нүүрс худалдан авсан байна. Тухайлбал:

1. Тайлант онд Багануур ХК-тай байгуулсан Д-2025/02(25/13-01) тоот гэрээний дагуу 2400.0 мян.тн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 2433.6 мян.тн худалдан авсан байна. Компанийн Ерөнхий инженерийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02/1140 тоот албан бичигт "2025 оны 3 дугаар улиралд ДЦС-3 ТӨХК-ийн турбин №9 гэмтсэнтэй холбоотойгоор ачааллын тодорхой хувийг манай станцад шилжүүлэн өгсөн тул эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна. Үүний улмаас сүүлийн хагас жилд нүүрсний дутагдалд орох магадлал үүсэж болзошгүй байна. Иймд бидний нөхцөл байдлыг харгалзан үзэж 2025 оны сүүлийн хагас жилд 30.0 мян.тн нүүрсийг нэмэлтээр нийлүүлж өгнө үү" гэсэн хүсэлтийг үндэслэн нэмэлт нүүрсийг нийлүүлсэн байна. Гэвч гэрээнд заасан хэмжээнээс 3.6 мян.тн, буюу 197.9 сая төгрөгийн нүүрсийг илүү татан авсан байна.

2. Тайлант онд Шивээ-Овоо ХК-тай байгуулсан Д-2025/07 (ШО25-1/01) тоот гэрээний дагуу 1960.0 мян.тн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 1961.6 мян.тн нүүрс нийлүүлсэн байна. Гэрээнд заасан хэмжээнээс 1.6 мян.тн буюу 81.1 сая төгрөгийн нүүрсийг илүү татан авсан байна. Нийт 5.2 мян.тн буюу 279.0 сая төгрөгийн нүүрсийг гэрээнд заасан хэмжээнээс илүү татан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тайлант онд байгуулсан гэрээнд зааснаас илүү нүүрс татан авсан, нэмэлт гэрээ байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 5.** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1 ангиллын 285 нэр төрлийн 2,658.1 сая төгрөгийн хөрөнгийг сүүлийн 3-5 жилд дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" гэж заасантай тус тус нийцээгүй, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 6.** Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр, ажилчдын тэтгэмжийн нөөцтэй холбоотой түр зөрүүгийн тооцооллыг хийж бүртгэсэн боловч элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй, өмнөх оны 1,673.2 сая төгрөгийн тооцоололд хөдөлгөөн хийгээгүй байна.

бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", НББОУС 12 Орлогын албан татвар, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын Тайлбар 23 Орлогын татварын тодорхой бус байдал, Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал"-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 7.** Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн нэр дээрх Богдхан уулын дархан цаазат газрын бүсэд 2 га газрын "Газар ашиглах эрх"-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/337 дугаар тушаалаар сунгуулах хүсэлт гаргаагүй, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, газраа 2 жил дараалан ашиглаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон байна. Тус газар дээр Экоцогц Шийдэл ХХК-тай "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын захиалгат хяналт баталгааны ажил хийлгэх" 15.5 сая төгрөгийн Д/2025-346 дугаар гэрээг байгуулж, 2025 оны 10 дугаар сард 9.3 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, САГ/2026/28/НА-СТА-ТӨҮГ

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

ашиглах”, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Захирал дараах эрх, үүрэгтэй”, 2 дах хэсэгт “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Газар ашиглах эрх хүчингүй болсон байхад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын захиалгат хяналт баталгааны ажил хийлгэх гэрээ байгуулж, төлсөн урьдчилгаа төлбөрийг буцаан авах арга хэмжээг авах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавиагүй, зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 8.** Гэгээн Цайдам ХХК-тай хийсэн Д/2025-248 дугаар гэрээний дагуу 4.6 сая төгрөгийн 3 ширхэг хамгаалалтын блокийн буцаахгүй клапан CV2-20-P-0-5-00-г дутуу хүлээн авсан боловч орлогод бүрэн бүртгэсэн нь бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасантай нийцэхгүй байна..

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээний дагуу хөрөнгийг бүрэн хүлээн аваагүй, бүртгэлээр тавих дотоод хяналтыг хангалтгүй хийсэн зөрчлийг арилгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 9.** Бараа материал худалдан авах тухай гэрээний хэрэгжилтийг шалгахад бараа материалаа дутуу хүлээн авсан, бараа огт нийлүүлэгдээгүй, урьдчилгаа шилжүүлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй зэрэг дараах зөрчлүүд байна. Үүнд:

1. 2022 оны 3,671.7 сая төгрөгийн 76 гэрээт ажил байгаагаас 4 гэрээний 208.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн;
2. 2023 оны 3,539.1 сая төгрөгийн 46 гэрээт ажил байгаагаас 223.3 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, 444.7 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн;
3. 2024 оны 2,044.6 сая төгрөгийн 64 гэрээт ажил байгаагаас 15 гэрээнд 383.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн,
4. 2025 онд 7 байгууллагатай хийсэн 1,822.6 сая төгрөгийн гэрээний хэрэгжилт огт хангагдаагүй, 3 гэрээнд тооцоо нийлсэн акт үйлдээгүй байхад гэрээний заалт, мөнгөн хөрөнгийн журам зөрчиж, 746.8 сая төгрөгийг шилжүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө", Мөнгөн хөрөнгийн журмын 6.2.2-т "Дараах САГ/2026/28/НА-СТА-ТӨҮГ

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

тохиолдолд үлдэгдэл төлбөрийг шилжүүлэхэд гэрээ дүгнэсэн актыг заавал хийсэн байх шаардлагатай (Гэрээнд заасан ажил үйлчилгээ, бараа материалыг бүрэн нийлүүлсний дараа сүүлийн төлбөрийг шилжүүлэхэд)", Бараа нийлүүлэх гэрээний 3.2-т "Барааг нийлүүлж гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дараа хүлээн авсан барааны төлбөрийг Захиалагч Нийлүүлэгч талд 90 хоногт багтаан төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээний хэрэгжилт хангагдаагүй, хэрэгжилтийг дүгнэж акт үйлдээгүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байхад мөнгөн хөрөнгийн журам зөрчин төлбөрийг шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 10.** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй батлаагүйгээс 527.0 сая төгрөгийн ган лист худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр МЭЗ ХХК-тай 287.0 сая төгрөгийн Д/2025-091 дугаар гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах", 4 дэх хэсэгт "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг", 6 дах хэсэгт "төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй батлаагүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 11.** Харьцуулалтын арга ашиглахаас зайлсхийж, төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар тайлант онд 21.5 сая төгрөгийн хонины мах худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Харьцуулалтын арга ашиглахаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 12.** Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр, төсөвт өртгийг хувааж, нийт 742.4 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал:

- Ханжинбулаг ХХК-аас нийт 411.7 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг 4 хувааж, Д/2025-036 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор I секц, Д/2025-118 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор II секц, Д/2025-131 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын I секц, Д/2025-173 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын II секцийг тус тус худалдан авсан;
- Ариун цэврийн ерөөний засварын нийт 186.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 3 хувааж, Астар Анд ХХК-тай Д/2025-202, Д/2025-329 дугаар гэрээг, Сонгинотамир ХХК-тай Д/2025-333 дугаар гэрээг тус тус байгуулсан;
- Нээлттэй тендер шалгаруулах аргаар Эсрэг осмос блок №3 ажлыг гүйцэтгүүлэхээр Гути ирээдүй ХХК шалгарч 548.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Д/2025-168 дугаар гэрээг байгуулсан боловч тус компаниар 144.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эсрэг осмос блок №1 /ЭО №1-н орох шугам/-ын ажил гүйцэтгүүлэх Д/2025-167 дугаар гэрээг байгуулж, дээрх нээлттэй тендер шалгаруулахаас тусад нь төсөвт өртгийг хувааж, харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг хувааж, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 13.** Компанийн Худалдан авах ажиллагааны хэлтсээс "Өрлөг дулаалгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах" ДЦС4/20250101040 дугаар 2,064.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерийн баримт бичигт хүний нөөц нь нийгмийн даатгалын шимтгэлээр баталгаажсан, сүүлийн 2 жилийн хугацаанд тухайн байгууллагад ажилласан байх шаардлагыг тавьсан байна. Гэвч тендерт оролцогчийн хүний нөөцийн хувьд 24 сарын хугацаанд тухайн байгууллагад ажилласан болохыг нотлох нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээлэл болон холбогдох баримт бичгийг тендерийн материалд бүрэн хавсаргаагүй байхад үнэлгээний хорооноос уг нөхцөлийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулсан баримтгүйгээр үнэлгээ хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана", Тендерийн өгөгдлийн хүснэгт ТШЗ 19.1-д "... ажилтан бүгд сүүлийн 2 жил тухайн байгууллагад ажилласан байх шаардлагатай ба энэ нь НДШ-ээр баталгаажсан байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерийн баримт бичгийг тусгасан заалтыг мөрдлөг болгоогүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

**Илрүүлэлт 14.** Тайлант онд зохион байгуулсан "ҮТБ-ны ДС-ын хэсгийн дээврийн их засварын ажил гүйцэтгэх" 311.7 сая төгрөгийн нээлттэй тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжийг гүйцэтгэх захирал баталгаажуулаагүй, мөн хэрэгцээ шаардлага, ажлын эзлэхүүнийг бодитой төлөвлөөгүйгээс нэмэлтээр 44.8 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.2.3-д "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөл, арга хэмжээний нээлттэй тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжийг гүйцэтгэх захирал баталгаажуулаагүй, хэрэгцээ шаардлага, ажлын эзлэхүүнийг бодитой төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. **Үүнд:**

### 1. Татварын тайлагналтай холбоотой асуудал

**Илрүүлэлт 1.** Тус байгууллагад ажиллаж байгаад нас барсан 8 албан хаагчийн гэр бүлийн гишүүдэд нас барсны дараах хугацааны цалингийн зөрүү, урамшуулалд 55.0 сая төгрөгийг тооцож олгохдоо 5.5 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаж, нас барсан албан хаагчийн нэр дээр татварын албанд тайлагнасан байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Иргэний эрх зүйн чадвар нь иргэнийг төрсөн үеэс эхэлж нас барснаар дуусгавар болно” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тус байгууллагад ажиллаж байгаад нас барсан, хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон ажилчдын аливаа тэтгэмж, урамшууллыг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг мөнгө хүлээн авч, орлого олж байгаа хүний нэр дээр тайлагнаж байх.

### 2. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

**Илрүүлэлт 2.** Тайлант онд компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээний 9.6-д “Гүйцэтгэх захирлын тушаалаар Монгол Улсын төрийн дээд шагнал Хөдөлмөрийн баатарт 100,000.00 төгрөгийн, Гавьяат ажилтанд 20,000.00 төгрөгийн, Засгийн газрын шагнал Эрчим хүчний тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 15,000.00 төгрөгийн, бусад салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 10,000.00 төгрөгийн урамшууллыг сар бүр олгох бөгөөд жилд 2 удаа олгоно” гэсэн заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/460 дугаар тушаалаар 142.5 сая төгрөг, 2025 оны Б/875 дугаар тушаалаар 109.0 сая төгрөг, нийт 251.5 сая төгрөгийн урамшууллыг Ахмадын хороонд бүртгэлтэй ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдсан, тэтгэвэр тогтоолгосон иргэд болон одоо ажиллаж байгаа ажилчдад олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.5-д “Шагналыг байгууллагын, Засгийн газрын, төрийн дээд шагнал гэсэн дарааллаар олгоно. Мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл дурсгахаас бусад шагналыг төрийн албан хаагчид давхардуулан олгохгүй бөгөөд тухайн ажилтны ажлын үр дүн өмнөх түшингээс ахисан, сахилгын болон ёс зүйн зөрчилгүй, энэ журмын 1.2-т заасан болзлыг хангаж, өмнөх шагналаас хойш 3-аас доошгүй жил ажиллаж байгаа бол дараагийн шатны шагналыг олгох зарчим баримтална”, 1.7-д “Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хамтын гэрээнд холбогдох хууль, дүрмээс давсан заалтыг тусгасан зөрчлийг арилгах, цаашид дахин олгохгүй байх.

### 3. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

**Илрүүлэлт 3.** Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээний 14.4-т “Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульд ажилтныг хамтын гэрээнд хамруулан сарын болон жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цол, ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Захиргаа олгоно” гэж заасныг үндэслэн тайлант онд Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 2024 оны 40.0 сая төгрөг, 2025 оны 30.0 сая төгрөг, нийт 70.0 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”,

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээний 3.11-т “үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний талаар Ажилтнуудад жилийн ажлын үр дүнг харгалзан 3-5 хүртэл сарын албан тушаалын ба тарифт гүйцэтгэлийн цалингийн дундаж хэмжээний нэмэгдэл хөлс олгоно. Нэмэгдэл хөлсний хэмжээг ТУЗ-өөр батлуулна. Нэмэгдэл хөлс олгох журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сонгуульт орон тоонд ажилласан албан хаагчид жилийн ажлын үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл хөлс, цол, ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг олгож, компанийн ашигт ажиллагааг бууруулахгүй байх.

#### 4. Бараа материалтай холбоотой асуудал

**Илрүүлэлт 4.** Компанийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/264 дүгээр тушаалаар "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаа, хөдөлмөр хамгааллын нөөцийн зүйлсийн жагсаалт", 2025 оны А/276 тушаалаар "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нормчлох, төлөвлөх, нийлүүлэх, захиалах, олгох, тайлагнах журам"-ыг баталсан боловч тус журамд ажлаас чөлөөлөгдөж буй ажилтнаас ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаатай холбоотой тооцоог эргэн төлүүлэх талаар зохицуулалт тусгаагүйгээс ажлаас гарсан ажилтнуудаас нормын хувцасны ашиглалтын тооцоог хийгээгүй, ашиглаагүй хугацааны мөнгийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 14.2-т зааснаас бусад өөрийн онцлогт тохирсон дотооддоо мөрдөх анхан шатны баримт, маягтыг дүрэмдээ заасан эрх бүхий удирдах байгууллагаар батлуулан мөрдөж болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудаас нормын хувцасны ашиглалтын тооцоог хийж, ашиглаагүй хугацааны мөнгийг нөхөн төлүүлэх талаар зохицуулалтыг холбогдох журамд тусгах.

#### 5. Бараа материалын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт 5.** Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь дараах байгууллагуудаас Гүйцэтгэх захирлын тушаалгүй, тухайн байгууллагуудын ирүүлсэн хүсэлт болон албан бичигт холбогдох албан тушаалтанд цохолт хийж, бараа материалыг зээлээр өгч, буцаан авсан байна. Үүнд:

- Эрдэнэт дулааны цахилгаан станц ТӨХК-д 62,850 кг мазутыг олгож, тооцоог Интерстандарт нефть ХХК-аас 62,850 кг маузыг нийлүүлж зөрүү 2.0 сая төгрөгийг масолын төлбөрт суутгасан;
- Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа үйлдвэрийн Давс 15 тонныг зээлээр өгч, буцаан авсан;
- Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 5 нэр төрлийн 4.2 сая төгрөгийн барааг зээл, хугацаа хоцруулан тооцоог дуусгасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын баталсан төсөвт багтаан хэрэгцээт бараа материалыг худалдан авч, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг гаргуулж, бараа материалыг зарцуулж байх.

## 6. Татварын тайлантай холбоотой асуудал

**Илрүүлэлт 6.** Татварын тайлантай холбоотой өглөг, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна", Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", 83.6-д "Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын тайлантай холбоотой өглөг, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримталж ажиллах.

## 7. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт 7.** Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 8.9 сая төгрөгийн нэмэлт засварын ажлыг Д/2025-193 дугаар Серверийн өрөөний газардуулга, 112 тоот өрөө, сарнай өрөөний их засварын ажил гүйцэтгэх гэрээний нэмэлт гэрээ болгон гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлсэн байна. Тус гэрээнд заасан хугацаанаас 2 хоног хэтэрсэн алдангийг тооцоогүй гүйцэтгэлийг олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.2.3-д "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр дүгнэж, гэрээнд заасны дагуу хугацаа хэтэрсэн алданги, анзыг тухай бүр бүрэн тооцож байх.

## 8. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

**Илрүүлэлт 8.** Yokogawa Electric Korea Co., Ltd-тай байгуулсан "Зуух №1-4-ийн хяналт удирдлагын DCS системийн шинэчлэлт"-ийн Г/2025-02 дугаар гэрээг 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр дүгнэхдээ техникийн санал, нийлүүлэлтийн хүрээнд заасан V-net/IP Interface card: 11 ком, сүлжээний төхөөрөмж 1 багц гэснийг гэрээ дүгнэсэн актад тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", гэрээний 3.2-т "Бүх тоног

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

төхөөрөмж, материалыг ... DAP нөхцөлийн үндсэн дээр нийлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээ дүгнэсэн актад хүлээн авсан бараа, бүтээгдэхүүнийг бүрэн тусгаж, гэрээнд заасны дагуу бүрэн хүлээн авч, акт үйлдэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллагад ажиллаж байгаад нас барсан 8 албан хаагчийн гэр бүлийн гишүүдэд нас барсны дараах хугацааны цалингийн зөрүү, урамшуулалд 55,055.8 мянган төгрөгийг тооцож олгохдоо 5,505.5 мянган төгрөгийн ХХОАТ суутгаж, нас барсан албан хаагчийн нэр дээр татварын албанд тайлагнасан байна.	1	55,055.9					1	55,055.9				
Тайлант онд компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан "Хамтын гэрээ"-ний Ес.Шагнал урамшуулал хэсгийн 9.6-д "Гүйцэтгэх захирлын тушаалаар Монгол Улсын төрийн дээд шагнал Хөдөлмөрийн баатарт 100,000.00 төгрөгийн, Гавьяат ажилтанд 20,000.00 төгрөгийн, Засгийн газрын шагнал Эрчим хүчний тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 15,000.00 төгрөгийн, бусад салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 10,000.00 төгрөгийн урамшууллыг сар бүр олгох бөгөөд жилд 2 удаа олгоно" гэсэн заалтыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2025 оны Б/460 дугаар тушаалаар 142,515.0 мянган төгрөг, 2025 оны Б/875 дугаар тушаалаар 109,040.0 мянган төгрөг, нийт 251,555.0 мянган төгрөгийн урамшууллыг Ахмадын хороонд бүртгэлтэй ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдсан, тэтгэвэр тогтоолгосон иргэд болон одоо ажиллаж байгаа ажилчдад олгосон байна.	1	251,555.0					1	251,555.0				

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан "Хамтын гэрээ"-ний 14.4-т "Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтныг хамтын гэрээнд хамруулан сарын болон жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цол, ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Захиргаа олгоно" гэж заасныг үндэслэн тайлант онд Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргад 2024 оны 40,000.6 мянган төгрөг, 2025 оны 30,007.9 мянган төгрөг, нийт 70,008.6 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.	1	70,008.6					1	70,008.6				
Тайлант онд нийт 52,233,211.5 мянган төгрөгийн авлага үүссэнээс шүүхийн шийдвэртэй 246,842.6 мянган төгрөг, 2024-2025 оны 1 сард гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газарт 226,892.0 мянган төгрөгийн авлагыг шилжүүлсэн боловч тайлант хугацаанд барагдаагүй, 17,447.5 мянган төгрөгийн авлагатай 2 аж ахуй нэгжийг эрэн сурвалжлах шийдвэр гарсан боловч одоогоор барагдаагүй, мөн урьдчилж орсон орлогын 15 аж ахуй нэгжтэй 14,535.2 мянган төгрөгийн авлага, баталгаат хугацааны барьцааны өглөг 268,201.4 мянган төгрөг, гадаадын аж ахуй нэгжтэй байгуулсан 4 гэрээт ажлын өглөг 2,472,945.6 мянган төгрөг, дотоодын 5 аж ахуй нэгжтэй байгуулан гэрээний үлдэгдлийн өглөг 65,442.0 мянган төгрөгийг үлдэгдлийг тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	1	2,821,124.2				1	2,821,124.2					
Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 7 жилийн хугацаатай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар гэрээгээр 70.6 сая евро буюу 260,093,860.5 мянган төгрөгийн урт хугацаат зээл авсан байна. Өмнөх оны зээлийн эргэн төлөлтөөс төлөгдөөгүй үлдсэн 3,392,231.5 мянган төгрөгийн үндсэн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн 2025 оны хуваарийн дагуу төлөөгүйгээс 33,568,925.6 мянган төгрөгийн үндсэн төлбөр, 30,118,756.8 мянган төгрөгийн хүүгийн төлбөр, 24,180.2 мянган төгрөгийн нэмэгдсэн хүүгийн төлбөр, нийт 67,104,094.3 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй болсон байна.	1	67,104,094.3				1	67,104,094.3					

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

<p>Тайлант оны эхэнд 1347 тонн мазутын үлдэгдэлтэй байхад Интер стандарт нефть ХХК-тай 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр 2,315,700.0 мянган төгрөгийн 930 тонн мазут худалдан авах Д/2025-290 дугаар гэрээг байгуулсан байна. Тайлант оны эцэст 1,411.15 тн буюу 3,156,081.9 мянган төгрөгийн мазутын үлдэгдэлтэй байгаа нь Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан "Аюулгүй нөөц бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт, өөрчлөх, нөхөн хангалт хийх журам"-ийн 6.1.1 а-д "Мазут нь горимын зохицуулалтаар хамгийн их зарцуулах 10 хоногийн нөөцтэй байх", АШБ-/СҮАЖ-СБХ08/01 маягтад мазутын нөөцийг улиралд 300 тн байхаар тогтоосноос 1,111.15 тонн буюу 2,485,122.3 мянган төгрөгөөр илүү нөөц үүсгэсэн байна.</p>	1	2,485,122.3			1	2,485,122.3					
<p>Нүүрс худалдан авах гэрээг Багануур ХК, Шивээ-овоо ХК-тай байгуулсан байна. Үүнээс: 1. Тайлант онд Багануур ХК-тай байгуулсан Д-2025/02(25/13-01) тоот гэрээний дагуу 2400.0 мян.тн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 2433.6 мян.тн худалдан авсан байна. Компанийн Ерөнхий инженерийн 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02/1140 тоот албан бичигт "2025 оны 3 дугаар улиралд ДЦС-3 ТӨХК-ийн турбин №9 гэмтсэнтэй холбоотойгоор ачааллын тодорхой хувийг манай станцад шилжүүлэн өгсөн тул эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна. Үүний улмаас сүүлийн хагас жилд нүүрсний дутагдалд орох магадлал үүсэж болзошгүй байна. Иймд бидний нөхцөл байдлыг харгалзан үзэж 2025 оны сүүлийн хагас жилд 30.0 мян.тн нүүрсийг нэмэлтээр нийлүүлж өгнө үү" гэсэн хүсэлтийг үндэслэн нэмэлт нүүрсийг нийлүүлсэн байна. Гэвч гэрээнд заасан хэмжээнээс 3.6 мян.тн, буюу 197,902.1 мянган төгрөгийн нүүрсийг илүү татан авсан байна. 2. Тайлант онд Шивээ-Овоо ХК-тай байгуулсан Д-2025/07 (ШО25-1/01) тоот гэрээний дагуу 1960.0 мян.тн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 1961.6 мян.тн нүүрс нийлүүлсэн байна. Гэрээнд заасан хэмжээнээс 1.6 мян.тн буюу 81,166.6 мянган төгрөгийн нүүрсийг илүү татан авсан байна. Нийт 5.2 мян.тн буюу 279,068.7 мянган төгрөгийн нүүрсийг гэрээнд заасан хэмжээнээс илүү татан авсан байна.</p>	1	279,068.7			1	279,068.7					
<p>Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1 ангиллын 285 нэр төрлийн 2,658,067.2 мянган төгрөгийн хөрөнгийг сүүлийн 3-5 жилд дахин үнэлж бүртгээгүй байна.</p>	1	2,658,067.2			1	2,658,067.2					

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр, ажилчдын тэтгэмжийн нөөцтэй холбоотой түр зөрүүгийн тооцооллыг хийж бүртгэсэн боловч элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй байна.	1	1,673,209.9			1	1,673,209.9						
Компанийн Гүйцэтгэх захирлын 2024 оны А/264 дүгээр тушаалаар "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаа, хөдөлмөр хамгааллын нөөцийн зүйлсийн жагсаалт", 2025 оны А/276 тушаалаар "Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг нормчлох, төлөвлөх, нийлүүлэх, захиалах, олгох, тайлагнах журам"-ыг баталсан ч тус журамд ажлаас чөлөөлөгдөж буй ажилтнуудаас ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн эдэлгээний хугацаатай холбоотой тооцоог эргэн төлүүлэх, барагдуулах талаар зохицуулалт тусгаагүйгээс ажлаас гарсан ажилтнуудаас нормын хувцасны хугацааны тооцоог хийгээгүй, ашиглаагүй хугацааны мөнгийг нөхөн төлүүлээгүй байна.	1	-			1	-						
Дулааны IV цахилгаан станц ТӨХК нь дараах байгууллагуудаас Гүйцэтгэх захирлын тушаалгүй, тухайн байгууллагуудын ирүүлсэн хүсэлт болон албан бичигт холбогдох албан тушаалтанд цохолт хийж, бараа материалыг зээлээр өгч, буцаан авсан байна. Үүнд: 1. Эрдэнэт дулааны цахилгаан станц ТӨХК-д 62,850 кг мазутыг олгож, тооцоог Интерстандарт нефть ХХК-аас 62,850 кг маузыг нийлүүлж зөрүү 2,054.4 мянган төгрөгийг масолын төлбөрт суутгасан; 2. Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа үйлдвэрийн Давс 15 тонныг зээлээр өгч, буцаан авсан; 3. Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн 5 нэр төрлийн 4,253.2 мянган төгрөгийн барааг зээл, хугацаа хоцруулан тооцоог дуусгасан байна.	1	153,899.5			1	153,899.5						

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Дулааны 4 цахилгаан станц ТӨХК-ийн нэр дээрх Богдхан уулын дархан цаазат газрын бүсэд 2 га газрын "Газар ашиглах эрх"-ийг БОУАӨ-ийн сайдын 2025.05.19-ний өдрийн А/337 дугаар тушаалаар сунгуулах хүсэлт гаргаагүй, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, газраа 2 жил дараалан ашиглаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон байна. Тус газрыг ашиглах хугацааг сунгуулах хүсэлт өгөөгүй, хүчингүй болсон газар дээр Эжоцогц Шийдэл ХХК-тай 15,500.0 мянган төгрөгийн Д/2025-346 дугаар "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын захиалгат хяналт баталгааны ажил хийлгэх" гэрээг байгуулж, 9,300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	1	15,500.0			1	15,500.0					
Гэгээн Цайдам ХХК-тай хийсэн Д/2025-248 тоот гэрээний дагуу хамгаалалтын блокны буцаахгүй клапан CV2-20-P-0-5-00-аас 4,594.0 мянган төгрөгийн 3ш-ийг дутуу авсан боловч орлогод бүрэн бүртгэсэн байна.	1	4,594.0			1	4,594.0					
Бараа материал худалдан авах тухай гэрээний хэрэгжилтийг шалгахад бараа материалаа дутуу хүлээн авсан, бараа огт нийлүүлэгдээгүй, урьдчилгаа шилжүүлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй зэрэг дараах зөрчлүүд байна. Үүнд: 1. 2022 оны 3,671,742.7 мянган төгрөгийн 76 гэрээт ажил байгаагаас 4 гэрээний 208,040.4 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн; 2. 2023 оны 3,539,112.1 мянган төгрөгийн 46 гэрээт ажил байгаагаас 223,294.7 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж, 444,691.8 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн; 3. 2024 оны 2,044,626.1 мянган төгрөгийн 64 гэрээт ажил байгаагаас 15 гэрээнд 383,364.9 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн, 4. 2025 онд 7 байгууллагатай хийсэн 1,822,566.6 мянган төгрөгийн гэрээний хэрэгжилт огт хангагдаагүй, 3 гэрээнд 746,823.5 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн.	1	2,569,390.0			1	2,569,390.0					
Татварын тайлантай холбоотой өглөг, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй байна.	1	503,000.0					1	503,000.0			
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй батлаагүйгээс 526,960,884.1 мянган төгрөгийн ган лист худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр МЭЗ ХХК-тай 286,950.2 мянган төгрөгийн Д/2025-091 дугаар гэрээ байгуулсан байна.	1	289,950.2			1	289,950.2					

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Харьцуулалтын арга ашиглахаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар тайлант онд 21,551.0 мянган төгрөгийн хонины мах худалдан авсан байна.	1	21,551.0			1	21,551.0					
Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендэр шалгаруулалт зохион байгуулахгүйгээр, төсөвт өртгийг хувааж, нийт 742,429.1 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал: 1. Ханжинбулаг ХХК-иас нийт 411,687.1 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг 4 хувааж, Д/2025-036 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор I секц, Д/2025-118 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор II секц, Д/2025-131 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын I секц, Д/2025-173 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын II секцийг тус тус худалдан авсан; 2. Ариун цэврийн өрөөний засварын нийт 186,417.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 3 хувааж, Астар Анд ХХК-тай Д/2025-202, Д/2025-329 дугаар гэрээг, Сонгинотамир ХХК-тай Д/2025-333 дугаар гэрээг тус тус байгуулсан; 3. Нээлттэй тендер шалгаруулах аргаар Эсрэг осмос блок №3 ажлыг гүйцэтгүүлэхээр Гути ирээдүй ХХК шалгарч 548,937.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Д/2025-168 дугаар гэрээг байгуулсан боловч тус компаниар 144,324.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Эсрэг осмос блок №1 /ЭО №1-н орох шугам/-ын ажил гүйцэтгүүлэх Д/2025-167 дугаар гэрээг байгуулж, дээрх НТШ-аас тусад нь төсөвт өртгийг хувааж, харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.	1	742,429.1			1	742,429.1					
ДЦС4/20250101040 дугаар 2,064,641.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Өрлөг дулаалгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерийн баримт бичигт хүний нөөцийг НДШ-ээр баталгаажсан сүүлийн 2 жил тухайн байгууллагад ажилласан гэж заасан боловч НДШ-ийн тодорхойлолтоор 24 сар ажилласан гэдгийг нотлох баримтыг тендер шалгаруулалтын баримтад хавсаргаж ирүүлээгүй байна.	1	2,064,641.3			1	2,064,641.3					
ҮТБ-ны ДС-ын хэсгийн дээврийн их засварын ажил гүйцэтгэх 311,722.1 мянган төгрөгийн нээлттэй тендерийн зөвлөмжийг гүйцэтгэх захирал баталгаажуулаагүй, хэрэгцээ шаардлага, ажлын эзлэхүүнийг бодитой төлөвлөөгүйгээс нэмэлтээр 44,840.8 мянган төгрөгийн гэрээг байгуулсан байна.	1	356,562.9			1	356,562.9					

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй 8,951.4 мянган төгрөгийн нэмэлт засварын ажлыг Д/2025-193 дугаар Серверийн өрөөний газардуулга, 112 тоот өрөө, сарнай өрөөний их засварын ажил гүйцэтгэх гэрээний нэмэлт гэрээ болгон гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлсэн байна. Мөн гэрээнд заасан хугацаанаас 2 хоног хэтэрсэн алдангийг тооцоогүй гүйцэтгэлийг олгосон байна.	1	8,951.4					1	8,951.4				
Yokogawa Electric Korea Co., Ltd-тай байгуулсан Г/2025-02 тоот "Зуух №1-4-н хяналт удирдлагын DCS системийн шинэчлэлт"-ийн гэрээг 2025/9/19-нд дүгнэхдээ техникийн санал, нийлүүлэлтийн хүрээнд заасан V-net/IP Interface card: 11 ком, сүлжээний төхөөрөмж 1 багц гэснийг гэрээ дүгнэсэн актад тусгаагүй байна.	1	-					1	-				
<b>НИЙТ ДҮН</b>	<b>22</b>	<b>84,127,775.6</b>	-	-	<b>14</b>	<b>83,085,305.1</b>	<b>8</b>	<b>1,042,470.4</b>	-	-	-	-

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Хариуцлага тооцуулах албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тус компани 2024 оны жилийн эцэст (1,556,834.8) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байхад Гүйцэтгэх захирлын "Жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл олгох тухай" 2025.02.18-ны өдрийн А/118 дугаар тушаалаар компанийн ажилчдад 7,998,573.3 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.	1	7,998,573.3					1	7,998,573.3
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ХАБЭМТөвд хамрагдах ажиллагсдын урьдчилан сэргийлэх үзлэг болон Firewall M470 total security лиценз худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч нэг эх үүсвэртэй гэж шууд гэрээ байгуулсан, мөн "Компанийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах" ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч харьцуулалтын аргаар тендер зарласан байна.	1	252,571.4				1	252,571.4	
Тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт болон, гэрээний тусгай нөхцөлд урьдчилгаа төлбөр олгохгүй гэж заасан боловч байгуулсан гэрээний ерөнхий нөхцөлд урьдчилгаа төлбөр олгоно гэж заасан нь тендерийн баримт бичиг дэх мэдээллүүд хоорондоо зөрүүтэй, тодорхойгүй байдлыг үүсгэсэн байна.	1	-					1	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй гэрээ хийж, ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг 2025.09.08-2025.09.24-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн боловч үзлэг, шинжилгээний нэгдсэн дүнгийн талаар тайланг авч, гэрээ дүгнэн ажлыг дуусгаагүй байна.	1	39,610.0					1	39,610.0
Тендерийн бичиг баримтын зөрчилтэй 5 аж ахуй нэгж, байгууллагын 1,546,863.7 мянган төгрөгийн гэрээт ажил байна. Шаардлага хангахгүй ижил төстэй ажлын туршлага байхгүй, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэрийн өртэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй компаниудыг шалгаруулснаас шалтгаалан бараа материал шаардлага хангахгүй буцах, засварын ажил удаашрах, төлбөр тооцоо он дамжин хийгдэх, гэрээ цуцлах зэрэг эрсдэлүүд үүссэн байна.	1	1,546,863.6				1	1,546,863.6	

**Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан**

Тендерийн бичиг баримтын боловсруулалттай холбоотой дараах нийтлэг зөрчил байна. 1. Өрлөг дулаалгын ажлын нээлттэй тендер шалгаруулалтад хараат бус гишүүн үнэлгээ өгөөгүй; 2. Үнэлгээний хорооны зөвлөмжид гүйцэтгэх захирлын шийдвэр тусгагдаагүй байна. Тухайлбал, ҮДЦС4/20250101057, 3. Үнэлгээний хорооны зөвлөмжид огноо бичигдээгүй байна. Тухайлбал, ДЦС4/20250101035, ДЦС4/20250101039, ДЦС4/20250101040, ДЦС4/20250101041, ДЦС4/20250101042, ДЦС4/20250101051, ДЦС4/20250101052, ДЦС4/20250101054, ҮДЦС4/20250101057, 4. ҮБ №2 ийн дээврийн засвар, өргөтгөлийн шүүлтүүр заалны таазны цонх солих ажлын гэрээг гүйцэтгэгч тал баталгаажуулаагүй, огноо бичигдээгүй, аудитын явцад хавсаргасан, 5. НТШ үнэлгээний хороо нь оролцогч байгууллагуудыг ерөнхий шаардлагад нийцсэн эсэхийг үнэлсний дараа шаардлага хангасан оролцогчдыг залруулга болон үнийн хөнгөлөлтийн хүснэгтээр байр эзлүүлж шалгаруулдаг процесстэй боловч шаардлага хангаагүй компаниудыг залруулга болон үнийн хөнгөлөлтийн хүснэгтэд оруулснаар тууштай байдал алдагдаж байна. 6. Зуухны лифт №1,2-н их засвар /Е2008-019А/ ажил гүйцэтгэх гэрээнд заасан ажлыг наряд хаасан тэмдэглэлтэй тулгаж үзэхэд 2025/7/31-нд дууссан боловч гэрээ дүгнэсэн актыг 2 сарын дараа буюу 2025/10/01-нд үйлдсэн байна.	1	-					1	-
Уралын турбины завод ХК-тай байгуулсан №79-16/540-2025 тоот "Нийлүүлэлтийн гэрээ" гэрээний 5.7-д ОХУ-ын ХҮТ-ын дэргэдэх Олон улсын арбитрын шүүхэд хандаж шийдвэрлэнэ, Yokogawa Electric Korea Co., Ltd-тай байгуулсан Г/2025-02 тоот "Зуух №1-4-н хяналт удирдлагын DCS системийн шинэчлэлт" гэрээний 11.7-д аливаа маргааныг Солонгосын арилжааны арбитрын зөвлөлийн олон улсын арбитрын журмын дагуу арбитраар эцэслэн шийдвэрлэнэ гэж заасан нь гадаад гэрээ байгуулах бүрт тухайн улсын арбитраар шийдвэрлэнэ гэж заасан тохиолдолд өндөр зардал гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.	1	-					1	-
Бохемиа Мюллер компанийн серви үйлчилгээний гэрээнд огноо тавигдаагүй байгаа нь гэрээний 2.1-д талууд гарын үсэг зурж, тамга дарснаас хойш 120 хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байна гэж заасантай холбогдуулан үзэхэд тухайн үйлчилгээ хэзээ дуусах, хүлээлгэж өгөх нь тодорхойгүй байна.	1	-					1	-
<b>ДҮН</b>	<b>8</b>	<b>9,837,618.3</b>	-	-	<b>2</b>	<b>1,799,435.0</b>	<b>6</b>	<b>8,038,183.3</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>30</b>	<b>93,965,393.9</b>	-	-	<b>16</b>	<b>84,884,740.1</b>	<b>14</b>	<b>9,080,653.7</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 730/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нийт 52,233,211,478.30 /Тавин хоёр тэрбум хоёр зуун гучин гурван сая хоёр зуун арван нэгэн мянга дөрвөн зуун далан найман төгрөг гучин мөнгө/-ний авлага үүссэнээс шүүхийн шийдвэртэй 246,842,590.45 /Хоёр зуун дөчин зургаан сая найман зуун дөчин хоёр мянга таван зуун ерэн төгрөг дөчин таван мөнгө/, 2024-2025 оны 1 дүгээр сард гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр Нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх газарт 226,891,995.85 /Хоёр зуун хорин зургаан сая найман зуун ерэн нэгэн мянга есөн зуун ерэн таван төгрөг наян таван мөнгө/-ний авлагыг шилжүүлсэн боловч тайлант хугацаанд барагдаагүй, Ариунбуян хур ХХК, Убаши системс ХХК-ийн 17,447,534.60 /Арван долоон сая дөрвөн зуун дөчин долоон мянга таван зуун гучин дөрвөн төгрөг жаран мөнгө/-ний авлагын эзэн холбогдогчийг эрэн сурвалжлах шийдвэр гарсан боловч тус авлага барагдаагүй;

Мөн урьдчилж орсон орлогын 15 аж ахуй нэгжээс авах 14,535,178.62 /Арван дөрвөн сая таван зуун гучин таван мянга нэг зуун далан найман төгрөг жаран хоёр мөнгө/-ний авлага, баталгаат хугацааны барьцааны 268,201,376.00 /Хоёр зуун жаран найман сая хоёр зуун нэг мянга гурван зуун далан зургаан/ төгрөгийн өглөг, гадаадын аж ахуй нэгжтэй байгуулсан 4 гэрээт ажлын 2,472,945,625.13 /Хоёр тэрбум дөрвөн зуун далан хоёр сая есөн зуун дөчин таван мянга зургаан зуун хорин таван төгрөг арван гурван мөнгө/-ний өглөг, дотоодын 5 аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээний үлдэгдлийн 65,442,036.16 /Жаран таван сая дөрвөн зуун дөчин хоёр мянга гучин зургаан төгрөг арван зургаан мөнгө/-ний өглөгийн үлдэгдлийг тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчил алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-37.Docx

1526180926

1. Шүүхийн шийдвэр гарсан авлагыг барагдуулахад анхаарч ажиллаагүй, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 731/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Турбоагрегат №1-4-ийн шинэчлэл төслийг хийх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-тай 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр 7 жилийн хугацаатай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 дугаар гэрээгээр 70.6 сая евро буюу 260,093,860,509.44 /Хоёр зуун жаран тэрбум ерэн гурван сая найман зуун жаран мянга таван зуун есөн төгрөг дөчин дөрвөн мөнгө/-ний урт хугацаат зээл авсан байна. Өмнөх оны зээлийн эргэн төлөлтөөс төлөгдөөгүй үлдсэн 3,392,231,465.46 /Гурван тэрбум гурван зуун ерэн хоёр сая хоёр зуун гучин нэгэн мянга дөрвөн зуун жаран таван төгрөг дөчин зургаан мөнгө/-ний үндсэн төлбөр, зээлийн эргэн төлөлтийн 2025 оны хуваарийн дагуу төлөөгүйгээс 33,568,925,861.80 /Гучин гурван тэрбум таван зуун жаран найман сая есөн зуун хорин таван мянга найман зуун жаран нэгэн төгрөг наян мөнгө/-ний үндсэн төлбөр, 30,118,756,758.80 /Гучин тэрбум нэг зуун арван найман сая долоон зуун тавин зургаан мянга долоон зуун тавин найман төгрөг наян мөнгө/-ний хүүгийн төлбөр, 24,180,177.19 /Хорин дөрвөн сая нэг зуун наян мянга нэг зуун далан долоон төгрөг арван есөн мөнгө/-ний нэмэгдсэн хүүгийн төлбөр, нийт 67,104,094,263.25 /Жаран долоон тэрбум нэг зуун дөрвөн сая ерэн дөрвөн мянга хоёр зуун жаран гурван төгрөг хорин таван мөнгө/-ний хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Монгол Улсын Хөгжлийн банктай байгуулсан ЗГ-ДЦС-3 2024-01 зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.1-д зээлдэгч эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн төлбөрийг төлнө, 5.2-т зээлийн төлбөрийг төлөөгүй эсхүл дутуу төлсөн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү, үндсэн хүү, үндсэн зээл гэсэн дарааллаар төлнө, Монгол Улсын Иргэний тухай хуулийн 453 дугаар зүйлийн 453.1-д Зээлдэгч авсан зээлээ хугацаанд нь төлөөгүй бол хэтэрсэн хугацааны хүү, гэрээнд заасан бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-37.Docx

1526180928


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төслийн зээлийн эргэн төлөлтийг графикт хугацаанд төлдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 732/А1560348

Улаанбаатар хот

САГ - 2026/28/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эхэнд 1347 тонн мазутын үлдэгдэлтэй байхад Интер стандарт нефть ХХК-тай 2025 оны 8 дугаар сарын 14-ний өдөр 2,315,700.00 мянган төгрөгийн 930 тонн мазут худалдан авах Д/2025-290 дугаар гэрээг байгуулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/43 дугаар тушаалаар баталсан "Аюулгүй нөөц бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт, өөрчлөх, нөхөн хангалт хийх журам"-ийн 6.1.1 а-д "Мазут нь горимын зохицуулалтаар хамгийн их зарцуулах 10 хоногийн нөөцтэй байх", АШБ-/СҮАЖ-СБХ08/01 маягтад мазутын нөөцийг улиралд 300 тн байхаар тогтоосноос 1,111.15 тонн буюу 2,485,122.3 мянган төгрөгөөр илүү нөөц үүсгэсэн, оны эцэст 1,411.15 тонн буюу 3,156.0 сая төгрөгийн мазутын үлдэгдэлтэй байна.




Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэх," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тайлант оны эцэст байх шаардлагатай нөөцөөс илүү мазут худалдан авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 733/А1560348

Улаанбаатар хот

САГ - 2026 /28/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хойшлогдсон хөрөнгө, өр төлбөрийн тооцоололд гадаад валютаар илэрхийлсэн өр төлбөр, ажилчдын тэтгэмжийн нөөцтэй холбоотой түр зөрүүгийн тооцооллыг хийж бүртгэсэн боловч элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй, өмнөх оны 1,673,209,875.52 /Нэг тэрбум зургаан зуун далан гурван сая хоёр зуун есөн мянга найман зуун далан таван төгрөг тавин хоёр мөнгө/-ний тооцоололд хөдөлгөөн хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", НББОУС 12 Орлогын албан татвар, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын Тайлбар 23 Орлогын татварын тодорхой бус байдал, Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал"-тай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Элэгдэх хугацаа болон капиталжуулалттай холбоотой элэгдэх хөрөнгийн өртгийн ялгаанаас үүссэн түр зөрүүг бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-37.Docx

1526180936



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 734/А156 0348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нүүрс худалдан авах гэрээг Багануур ХК, Шивээ-овоо ХК-тай байгуулж, гэрээнд зааснаас илүү нүүрс худалдан авсан байна. Тухайлбал:


- Тайлант онд Багануур ХК-тай байгуулсан Д-2025/02(25/13-01) тоот гэрээний дагуу 2400.0 мянган тонн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 2433.6 мянган тонн авсан нь гэрээнд заасан хэмжээнээс 197,902,075.00 /Нэг зуун ерэн долоон сая есөн зуун хоёр далан таван/ төгрөгийн 3.6 мянган тонн нүүрсийг илүү татан авсан байна.
- Тайлант онд Шивээ-Овоо ХК-тай байгуулсан Д-2025/07 (ШО25-1/01) тоот гэрээний дагуу 1960.0 мянган тонн нүүрс худалдан авахаас гүйцэтгэлээр 1961.6 мянган тонн нүүрс нийлүүлсэн нь гэрээнд заасан хэмжээнээс 81,166,613.00 /Наян нэгэн сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун арван гурван/ төгрөгийн 1.6 мянган тонн нүүрсийг илүү татан авсан байна. Нийт 279,068,688.00 /Хоёр зуун далан есөн сая жаран найман мянга зургаан зуун наян найман/ төгрөгийн 5.2 мянган тонн нүүрсийг гэрээнд заасан хэмжээнээс илүү татсанд, нэмэлт гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд байгуулсан гэрээнд зааснаас илүү нүүрс татан авсан, нэмэлт гэрээ байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 735/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 1 ангиллын 285 нэр төрлийн 2,658,067,196.66 /Хоёр тэрбум зургаан зуун тавин найман сая жаран долоон мянга нэг зуун ерэн зургаан төгрөг жаран зургаан мөнгө/-ний хөрөнгийг сүүлийн 3-5 жилд дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" гэж заасантай тус тус нийцэхгүй, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг үнэлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 736/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА -СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.


Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн нэр дээрх Богдхан уулын дархан цаазат газрын бүсэд 2 га газрын "Газар ашиглах эрх"-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/337 дугаар тушаалаар сунгуулах хүсэлт гаргаагүй, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, газраа 2 жил дараалан ашиглаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон байна. Тус газар дээр Экоцогц Шийдэл ХХК-тай "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын захиалгат хяналт баталгааны ажил хийлгэх" 15,500,000.00 /Арван таван сая/ төгрөгийн Д/2025-346 дугаар гэрээг байгуулж, 2025 оны 10 дугаар сард 9,300,000.00 /Есөн сая гурван зуун мянган/ төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-т "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах", 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-т "өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах", 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Захирал дараах эрх, үүрэгтэй", 2 дах хэсэгт "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Газар ашиглах эрх хүчингүй болсон байхад Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын захиалгат хяналт баталгааны ажил хийлгэх гэрээ байгуулж, төлсөн урьдчилгаа төлбөрийг буцаан авах арга хэмжээг авах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавиагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



С.Мөнх

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 737/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Гэгээн Цайдам ХХК-тай хийсэн Д/2025-248 дугаар гэрээний дагуу 4,594,012.00 /Дөрвөн сая таван зуун ерэн дөрвөн мянган арван хоёр/ төгрөгийн 3 ширхэг хамгаалалтын блокийн буцаахгүй клапан CV2-20-P-0-5-00-г дутуу хүлээн авсан боловч орлогод бүрэн бүртгэсэн нь бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний дагуу хөрөнгийг бүрэн хүлээн аваагүй, бүртгэлээр тавих дотоод хяналтыг хангалтгүй хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Н.Нямсүрэн

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
Н.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26-230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-37.Docx

1526180940



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 738/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА -СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Бараа материал худалдан авах тухай гэрээний хэрэгжилтийг шалгахад бараа материалыг дутуу хүлээн авсан, бараа огт нийлүүлэгдээгүй, урьдчилгаа шилжүүлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдэж, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй зэрэг дараах зөрчлүүд байна. Үүнд:

2025 онд 7 байгууллагатай хийсэн 1,822,566,551.00 /Нэг тэрбум найман зуун хорин хоёр сая таван зуун жаран зургаан мянга таван зуун тавин нэгэн/ төгрөгийн гэрээний хэрэгжилт огт хангагдаагүй, 3 гэрээний тооцоо нийлсэн акт үйлдээгүй байхад гэрээний заалт, мөнгөн хөрөнгийн журам зөрчиж, 746,823,463.31 /Долоон зуун дөчин зургаан мянга найман зуун хорин гурван мянга дөрвөн зуун жаран гурван төгрөг гучин нэгэн мөнгө/-ийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн үндэсний болон холбогдох стандарт, журам баталж, мөрдүүлэх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д "Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ", 208 дугаар зүйлийн 208.1-д "Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ", 211 дүгээр зүйлийн 211.1-д "Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө", Мөнгөн хөрөнгийн журмын 6.2.2-т "Дараах тохиолдолд үлдэгдэл төлбөрийг шилжүүлэхэд гэрээ дүгнэсэн актыг заавал хийсэн байх шаардлагатай (Гэрээнд заасан ажил үйлчилгээ, бараа материалыг бүрэн нийлүүлсний дараа сүүлийн төлбөрийг шилжүүлэхэд)", Бараа нийлүүлэх гэрээний 3.2-т "Барааг нийлүүлж гэрээ дүгнэсэн акт үйлдсэний дараа хүлээн авсан барааны төлбөрийг Захиалагч Нийлүүлэгч талд 90 хоногт багтаан төлнө" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-37.Docx

1526180942

өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний хэрэгжилт хангагдаагүй, хэрэгжилтийг дүгнэж акт үйлдээгүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байхад мөнгөн хөрөнгийн журам зөрчин төлбөрийг шилжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 739/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Харьцуулалтын арга ашиглахаас зайлсхийж, төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар тайлант онд 21,551,000.00 /Хорин нэгэн сая таван зуун тавин нэгэн мянган/ төгрөгийн хонины мах худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьцуулалтын арга ашиглахаас зайлсхийж төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулах аргаар худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

*Handwritten signature*



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 740/A1560348

Улаанбаатар хот

САГ - 2026/28/КА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр, төсөвт өртгийг хувааж, нийт 742,429,111.76 /Долоон зуун дөчин хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга нэг зуун арван нэгэн төгрөг далан зургаан мөнгө/-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тухайлбал:


- Ханжинбулаг ХХК-аас нийт 411,687,100.00 /Дөрвөн зуун арван нэгэн сая зургаан зуун наян долоон мянга нэг зуун/ төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг 4 хувааж, Д/2025-036 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор I секц, Д/2025-118 дугаар гэрээгээр Хурц уурын коллектор II секц, Д/2025-131 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын I секц, Д/2025-173 дугаар гэрээгээр Тэжээлийн усны хүйтэн коллекторын II секцийг тус тус худалдан авсан;
- Ариун цэврийн өрөөний засварын нийт 186,417,800.00 /Нэг зуун наян зургаан сая дөрвөн зуун арван долоон мянга найман зуун/ төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 3 хувааж, Астар Анд ХХК-тай Д/2025-202, Д/2025-329 дугаар гэрээг, Сонгинотамир ХХК-тай Д/2025-333 дугаар гэрээг тус тус байгуулсан;
- Нээлттэй тендер шалгаруулах аргаар Эсрэг осмос блок №3 ажлыг гүйцэтгүүлэхээр Гути ирээдүй ХХК шалгарч 548,937,800.00 /Таван зуун дөчин найман сая есөн зуун гучин долоон мянга найман зуун/ төгрөгийн төсөвт өртөгтэй Д/2025-168 дугаар гэрээг байгуулсан боловч тус компаниар 144,324,200.00 /Нэг зуун дөчин дөрвөн сая гурван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн төсөвт өртөгтэй Эсрэг осмос блок №1 /ЭО №1-н орох шугам/-ын ажил гүйцэтгүүлэх Д/2025-167 дугаар гэрээг байгуулж, дээрх нээлттэй тендер шалгаруулахаас тусад нь төсөвт өртгийг хувааж, харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг хувааж, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 741/A1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн Худалдан авах ажиллагааны хэлтсээс “Өрлөг дулаалгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах” ДЦС4/20250101040 дугаар 2,064,641,263.67 Хоёр тэрбум жаран дөрвөн сая зургаан зуун дөчин нэгэн мянга хоёр зуун жаран гурван төгрөг жаран долоон мөнгө/-ний төсөвт өртөгтэй ажлын тендерийн баримт бичигт хүний нөөц нь нийгмийн даатгалын шимтгэлээр баталгаажсан, сүүлийн 2 жилийн хугацаанд тухайн байгууллагад ажилласан байх шаардлагыг тавьсан байна. Гэвч тендерт оролцогчийн хүний нөөцийн хувьд 24 сарын хугацаанд тухайн байгууллагад ажилласан болохыг нотлох нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээлэл болон холбогдох баримт бичгийг тендерийн материалд бүрэн хавсаргаагүй байхад үнэлгээний хорооноос үг нөхцөлийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулсан баримтгүйгээр үнэлгээ хийсэн байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана”, Тендерийн өгөгдлийн хүснэгт ТШЗ 19.1-д “... ажилтан бүгд сүүлийн 2 жил тухайн байгууллагад ажилласан байх шаардлагатай ба энэ нь НДШ-ээр баталгаажсан байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерийн баримт бичгийг тусгасан заалтыг мөрдлөг болгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 742/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зохион байгуулсан "ҮТБ-ны ДС-ын хэсгийн дээврийн их засварын ажил гүйцэтгэх" 311,722,123.00 /Гурван зуун арван нэгэн сая долоон зуун хорин хоёр мянга нэг зуун хорин гурван/ төгрөгийн нээлттэй тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжийг гүйцэтгэх захирал баталгаажуулаагүй, мөн хэрэгцээ шаардлага, ажлын эзлэхүүнийг бодитой төлөвлөөгүйгээс нэмэлтээр 44,840,800.00 /Дөчин дөрвөн сая найман зуун дөчин мянга найман зуун/ төгрөгийн гэрээг байгуулсан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 48 дугаар зүйлийн 48.2.3-д "үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих", Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.1-т "Худалдан авах ажиллагааны зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 44 дүгээр зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, арга хэмжээний нээлттэй тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжийг гүйцэтгэх захирал баталгаажуулаагүй, хэрэгцээ шаардлага, ажлын эзлэхүүнийг бодитой төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 743/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шаардлага хангахгүй ижил төстэй ажлын туршлага байхгүй, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэрийн өртэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй компаниудыг шалгаруулснаас шалтгаалан нэр бүхий 5 аж ахуй нэгж, байгууллагын 1,546,863,645.32 /Нэг тэрбум таван зуун дөчин зургаан сая найман зуун жаран гурван мянга зургаан зуун дөчин таван төгрөг гучин хоёр мөнгө/-ний гэрээний бараа материал шаардлага хангахгүй буцах, засварын ажил удаашрах, төлбөр тооцоо он дамжин хийгдэх, гэрээ цуцлах зэрэг эрсдэлүүд үүссэн байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2-т "сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан", 26 дугаар зүйлийн 26.4.1-д "энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх", 48 дугаар зүйлийн 48.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ", 48.2.2-т "үнэлгээний хороо байгуулах", 52 дугаар зүйлийн 52.1-д "Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шаардлага хангахгүй ижил төстэй ажлын туршлага байхгүй, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэрийн өртэй, техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй байгууллагыг сонгон шалгаруулсан, бараа материал шаардлага хангахгүй буцах, засварын ажил удаашрах, төлбөр тооцоо он дамжин хийгдэх, гэрээ цуцлах зэрэг эрсдэл үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

*Н. Нямсүрэн*



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 744/А1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвд хамрагдах ажиллагсдын урьдчилан сэргийлэх үзлэг болон Firewall M470 total security лиценз худалдан авах ажлыг харьцуулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч нэг эх үүсвэртэй гэж шууд гэрээ байгуулсан, "Компанийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах" ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаар баталсан боловч харьцуулалтын аргаар тендер зарласан, нийт 252,571,352.00 (Хоёр зуун тавин хоёр сая таван зуун далан нэгэн мянга гурван зуун тавин хоёр) төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ажлын тендер шалгаруулах аргыг төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.9-т "Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална", 2.13-т "Төлөвлөгөөнд тусгагдсан тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, зохион байгуулах хугацаа, тендер шалгаруулалтын арга, бараа, ажил, үйлчилгээний төрөл, тухайн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, бүр захиалагч холбогдох өөрчлөлттэй холбоотой үндэслэлийг албан бичгээр үйлдэж, цахим системд хавсаргасан байх ба холбогдох этгээд түүнийг хянаж төлөвлөгөөний өөрчлөлтийг зөвшөөрнө" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчил алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-37.Docx

1526180974

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж батлуулалгүйгээр худалдан авах ажиллагааны аргачлалыг өөрчилж зохион байгуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

*Б.И*

*М. Монгтур*



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
Ж.МӨНХТУУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 745/A1560348

Улаанбаатар хот

САГ-2026/28/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй батлаагүйгээс 526,906,900.00 /Таван зуун хорин зургаан сая есөн зуун зургаан мянга есөн зуун/ төгрөгийн ган лист худалдан авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр МЭЗ ХХК-тай 286,950,200.00 /Хоёр зуун наян зургаан сая есөн зуун тавин мянга хоёр зуун/ төгрөгийн Д/2025-091 дугаар гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2-т төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах", 4 дэх хэсэгт "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг", 6 дах хэсэгт "төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй батлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлыг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Болдбаатар), Ерөнхий нягтлан бодогч (Ч.Алтангэрэл) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Н.Нямсүрэн



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ДОЛГОРСҮРЭН  
С.ОТГОНХОРЛОО  
Н.НЯМСҮРЭН